

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ"  
ХХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2026 оны 03 дугаар /дүгээр/  
сарын 12-ны өдрийн 26/12 тоот  
тушаалын хэвсгалт 01.



SOLOMON INVESTMENTS

## “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Баримт бичгийн төрөл/ Type:

“Компанийн засаглалын кодекс”-ийг  
хэрэгжүүлэх журам

Хамрах хүрээ/ Area:

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ”  
ХХК-ИЙН ажилтнуудад

Нууцын зэрэглэл/ Confidentiality:

Дотоодод нээлттэй

Баримт бичгийн дугаар/Number:

...*m / 26 / 25*...

Боловсруулсан/ Prepared by:

Хуулийн баг

Баталсан/ Approved by:

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ” ХХК-  
ийн Гүйцэтгэх захирал

Хуудасны тоо/ Page number:

...*3*... хуудас

Хянан нийцүүлэх давтамж:

...*нийг 1 удаа*...

Батлагдсан огноо/ Effective date:

2026 оны 03 дүгээр сарын 12

# **“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

## **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь компанийн дотоодод мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журам зааврыг “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчимд нийцүүлэн баталгаажуулах, дагаж мөрдсөнөөр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэвшил болгоход оршино.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- 2.1. Хөтөлбөрийн зорилт:
  - 2.1.1. Хувьцаа эзэмшигчдийн эрхийг баталгаажуулах;
  - 2.1.2. Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх;
  - 2.1.3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;
  - 2.1.4. Эрсдэлийн удирдлагыг сайжруулах;
  - 2.1.5. Хяналтын тогтолцоог сайжруулах.
- 2.2. Хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - 2.2.1. Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Компанийн засаглалын кодекс”-т тусгасан бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн мөрдөх;
  - 2.2.2. Компанийн бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд комплаенсын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх;
  - 2.2.3. Эрх бүхий албан тушаалтан, ажилтныг компанийн засаглалын сургалтад хамруулах;
  - 2.2.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх.

### **Гурав. Хөтөлбөрийн зохион байгуулалт**

- 3.1. Энэхүү хөтөлбөрийг компанийн ТУЗ нь өөрийн байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтцэд зохион байгуулалтад нийцүүлэн баталж, холбогдох бодлогын баримт бичиг, дүрэм, журам зааврын хэрэгжилтэд хяналт тавина.
- 3.2. ТУЗ нь дараах чиглэлээр бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг шинэчлэх буюу шинээр баталж мөрдөнө. Үүнд:
  - 3.2.1. Дүрэм, бодлогын баримт бичиг, заавар болон бусад.

№	Бодлогын баримт бичгийн нэр
1	Компанийн ёс зүйн дүрэм
2	Компанийн залгамж халааны бодлого
3	Компанийн цалин, урамшууллын бодлого
4	Компанийн ногдол ашгийн бодлого
5	Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого
6	Компанийн дотоод хяналтын журам
7	Компанийн комплаенсын хөтөлбөр ба хяналтын заавар
8	Компанийн бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахад баримтлах бодлого
9	Компанийн хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр
10	Компанийн шүгэл үлээх бодлого
11	Компанийн засаглалын кодекс хэрэгжүүлэх хөтөлбөр

### 3.2.2. Дотоод журам:

№	Дотоод журмын нэр
1	Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
2	Компанийн ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
3	Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны ажиллах журам
4	Компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам
5	Компанийн ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам
6	Компанийн Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам
7	Компанийн ХЭХ-ын зар хүргэх журам
8	Компанийн ТУЗ үйл ажиллагаа үнэлэх журам
9	Компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам

### Дөрөв. Тайлагнал, үнэлгээ

- 4.1. ТУЗ нь байгууллагын дүрэм, бодлогын баримт бичиг, заавар журам, загварыг боловсруулж мөрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, явцын талаар жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.
- 4.2. ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, компанийн засаглалын үнэлгээг компанийн үйл ажиллагааны тайланд тусгаж, компанийн цахим хуудсанд байршуулна.
- 4.3. ТУЗ нь жил бүрийн эхний улиралд багтааж, компанийн засаглалыг үнэлэх асуулгын дагуу өөрийн компанийн засаглалын түвшинг үнэлж болно.
- 4.4. ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай хамт Хороонд хүргүүлнэ.